



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 8/228

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1, 8.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний аймгийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Ажлын хэсгийн орлогч: Ё.Пүрэвсүрэн (Онцгой байдлын газрын дарга, хурандаа)

Ажлын хэсгийн гишүүд:

Г.Базар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Батбилгүүн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Батхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)

Ч.Дашбаяр (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

П.Лхагважав (Хөвсгөл Ус суваг ОНӨК-ийн захирал)

А.Өнөрбат (Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга)

А.Алтанцоож (Цагдаагийн газрын дарга, хурандаа)

Ж.Даваахүү (Мэдээлэл холбоо сүлжээний газрын дарга)

Г.Эрхэмбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Д.Түвшинбаяр (Эрүүл мэндийн газрын дарга)

З.Бадрал ("Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн захирал)

Ө.Баттулга (Авто тээврийн төвийн дарга)

Т.Раднаабүд (Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга)

Д.Цанлигрэнчин (Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн дарга)

Б.Галбадрах (Хөвсгөл АЗЗА ТӨХК-ийн захирал)

Б.Мөнгөнзул (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Д.Идэрмөнх (Мөрөн сумын Засаг дарга)

Г.Чинчулуун (Улаан загалмайн хорооны дарга)

Д.Хишигбат (Мөрөн Нисэх буудлын дарга)



2.

П.Даваадалай (Одон орон геофизикийн хүрээлэнгийн Хөвсгөл аймаг дахь "Хатгал" салбарын эрхлэгч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн  
дарга: Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

2. Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор бодит амьдралд хэрэгжихүйц байдлаар шинэчлэн боловсруулж батлуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН